

**АВТО ЗАМЫН  
ТҮГЖРЭЛИЙГ  
БУУРУУЛАХ  
ШИЙДЛИЙН ТАЛААРХ  
иргэдийн үнэлгээ**



# АГУУЛГА

**БҮЛЭГ 1:** ТҮГЖРЭЛИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД  
ОРОЛЦОХ БАЙДАЛ

**БҮЛЭГ 2:** ШИЙДЭЛ: ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ

**БҮЛЭГ 2.1** ТҮГЖРЭЛИЙН ШИЙДЛИЙН ХУВИЛБАНУУД: ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ

**БҮЛЭГ 2.2** НИЙТИЙН ТЭЭВРИЙГ САЙЖРУУЛАХ, LRT НЭВТРҮҮЛЭХ :  
ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ

**БҮЛЭГ 2.3** АВТО ЗОГСООЛ, АЧИЛТЫН ТӨЛБӨР, ТАТВАР ХУРААМЖ  
НЭМЭГДҮҮЛЭХ: ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ

БҮЛЭГ 1

# ТҮГЖРЭЛИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХ БАЙДАЛ



Mongolian Marketing  
Consulting Group

# УЛААНБААТАР ХОТОД ОРШИН СУУДАГ ӨРХҮҮДЭД БАЙГАА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛҮҮД



**СУУДЛЫН АВТОМАШИН**

**83%**

УБ хотын өрхүүдийн 83% нь суудлын автомашинтай байна.



**УНАДАГ ДУГУЙ**

**16%**

УБ хотын өрхүүдийн 16% нь унадаг дугуйтай байна.



**АЧААНЫ АВТОМАШИН**

**8%**

УБ хотын өрхүүдийн 8% нь ачааны автомашинтай байна.



**МОТОЦИКЛ**

**3%**

УБ хотын өрхүүдийн 3% нь мотоциклтой байна.



**СКҮҮТЕР**

**3%**

УБ хотын өрхүүдийн 3% нь сүүтэртэй байна.



**МИКРО АВТОБУС**

**2%**

УБ хотын өрхүүдийн 2% нь микро автобустай байна.



**МОПЕД**

**1%**


УБ хотын өрхүүдийн 1% нь мопедтай байна.

- УБ хотын өрхүүдийн дийлэнх нь суудлын автомашинтай байна.
- *Жич: Энд дурдсан тооцоололд өрхүүдэд дээрх тээврийн хэрэгсэл тус бүр хэдэн ширхэг байгаа эсэхийг тодруулаагүй буюу тухайн өрхөд ямар нэг байдлаар тус тээврийн хэрэгслүүд байгаа эсэхийг ерөнхийд нь тодруулсан болно.*



# АВТОМАШИН, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН МЭДЭЭЛЭЛ


## Танд өөрөө жолоодож замын хөдөлгөөнд оролцдог хувийн автомашин байгаа юу?



■ Байгаа ■ Байхгүй

- Иргэдийн 55% нь хувийн автомашин жолоодож Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцдог байна.


## Үйлдвэрлэсэн он



## Дундаж 2008 он


- Улаанбаатар хотод 2008 онд үйлдвэрлэсэн машин хамгийн их зорчдог байна.

## Автомашинны төрөл



- Автомашинтай иргэдийн 80% нь суудлын автомашинтай бол 16% нь бага оврын жийп, 4% нь том оврын жийптэй байна.


## Автомашинны хөдөлгүүрийн багтаамж




- Автомашинны хөдөлгүүрийн багтаамжийн хувьд 2500 см3-с бага буюу суудлын автомашин 82%-ийг эзэлж байна.

# АВТОЗАМЫН ТҮГЖРЭЛИЙН ҮНДСЭН ШАЛТГААН



- Улаанбаатар хотын замын түгжрэлийн үндсэн шалтгааны иргэд автомашины тоо хэт их болсонтой холбоотой гэж 70% нь үзэж байна.
- Томоохон зах, худалдааны төвүүд нь хотын төвдөө байрладаг болон хотын төвд зогсоол хүрэлцээгүй байдаг шалтгаанууд 2 болон 3-рт эрэмбэлэгдсэн байна.




# УЛААНБААТАР ХОТЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ





**Автомашинь зогсоолын хүрэлцээ** муу байна гэж иргэдийн 88% нь үнэлсэн байна.




**Түгжрэлийн нөхцөл байдлыг** нийт иргэдийн 84% нь муу байна гэж үнэллээ.



**Авто замын бүрэн бүтэн байдал** хангалтгүй муу байна гэж 62% нь үнэлжээ.



**Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг** иргэдийн 56% нь муу байна гэж үнэлсэн байна.




**Явган зорчигч алхах орчны таатай байдлыг** муу байна гэж иргэдийн 56% нь үнэлсэн байна.



# УЛААНБААТАР ХОТЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХДОО АШИГЛАДАГ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, ДАВТАМЖ

- Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцохдоо хувийн автомашин болон автобус, нийтийн тээврийг ашиглаж байгаа ба иргэдийн 38% нь 7 хоногт 5-аас дээш өдөр хувийн машинаар хөдөлгөөнд оролцож байгаа бол автобусаар 28% нь зорчдог байна.







# ИХ ТОЙРУУГИЙН БҮС РҮҮ ОРДОГ

## ЗОРИЛГО

- Их тойруугийн бүс рүү орж байгаа гол зорилго нь ажилдаа явах, худалдаа наймаа хийх дэлгүүр хэсэх, гэртээ харих зэрэг байна.
- 2 хүн тутмын 1 нь ажилдаа явах зорилгоор Их тойруугийн бүс рүү ордог байна.
- 26% нь хүүхдээ сургууль, цэцэрлэгт нь хүргэж өгөх зорилгоор орж байна.



# ИРГЭДИЙН ИХ ТОЙРУУГИЙН БҮС РҮҮ НЭВТРЭН АВДАГ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД




**3 ХҮН ТУТМЫН 1 НЬ**


**ИХ ТОЙРУУ РУУ ЯВЖ ТӨРИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭ АВДАГГҮЙ**

- УБ хотын 18-65 нийт иргэдийн 32% нь буюу 1/3 хэсэг нь их тойруу руу нэвтрэн төрийн үйлчилгээ авахгүй байна.
- Эдгээр иргэдийн насны бүлгээр нь авч үзвэл 18-20 настай иргэдийн 49%, 21-25 настай иргэдийн 40% нь их тойруу руу нэвтрэн төрийн үйлчилгээ авахгүй байна.
- Бусад насны бүлгийн хувьд 23%-33% нь их тойруу руу нэвтрэн төрийн үйлчилгээ авдаггүй байна. Үүнээс үзэхэд одоогоор нас залуу иргэд их тойруугаас төрийн үйлчилгээ авах байдал нь бусадтай харьцуулахад бага байна.


I



II



III



Үйлчилгээ	Хүний тоо	Эзлэх %
Бусад үйлчилгээ	33К	4%
Дүүргийн ЗДТГ-ын үйлчилгээ	33К	4%
Нийгмийн даатгалын үйлчилгээ	22К	3%
Нэг цэгийн үйлчилгээ	18К	2%
Газрын албаны үйлчилгээ	18К	2%
Татварын үйлчилгээ	15К	2%
Хотын захиргаанаас үйлчилгээ авдаг	14К	2%
Цагдаагийн байгууллагын үйлчилгээ	13К	2%
Төрийн яамны үйлчилгээ	12К	1%
Хорооны үйлчилгээ	10К	1%
Нийгмийн халамжийн үйлчилгээ	7К	1%
Шүүх, прокурорын үйлчилгээ	7К	1%

- УБ хотын иргэдийн 23% нь буюу 4 хүн тутмын 1 нь эмнэлгийн үйлчилгээ авахаар их тойруугийн бүс рүү нэвтэрдэг байна.
- Мөн 6% нь улсын бүртгэлийн үйлчилгээ авахаар, 6% нь сургуулийн үйлчилгээ авахаар их тойруугийн бүс рүү нэвтэрдэг байна.


# ЦЭЦЭРЛЭГ, БАГА СУРГУУЛИЙН ХҮҮХДИЙН ХАМРАН СУРАХ ТОЙРОГТОО СУРАЛЦАХ БАЙДАЛ




## ЦЭЦЭРЛЭГ БОЛОН БАГА СУРГУУЛИЙН НАСНЫ 3 ХҮҮХЭД ТУТМЫН 1 НЬ

### ХАРЬЯА СУРГУУЛЬ ЦЭЦЭРЛЭГТЭЭ ЯВДАГГҮЙ

Танай өрхөд цэцэрлэг болон бага ангид суралцдаг хүүхэд бий юу?



Харьяа бага сургууль болон цэцэрлэгээс өөр сургуульд суралцдаг хүүхэд бий юу?




- Бага сургуулийн насны болон цэцэрлэгийн насны хүүхдүүдийн 35% нь харьяа сургууль цэцэрлэгтэй явахгүй байна.





# ИХ ТОЙРУУГИЙН БҮС РҮҮ ХУВИЙН АВТОМАШИНТАЙ ОРДОГ ДАВТАМЖ

- Хувийн машинаа унан их тойруугийн бүс рүү 7 хоногийн 3-5 өдөр иргэдийн 40% нь тогтмол зорчдог байна. Үүнийг ажил эрхлэлтийн байдлаар харвал хувийн байгууллагад ажилладаг иргэдийн машинтай зорчих нь бага зэрэг илүү байна.
- Хувийн байгууллагынхан 7 хоногт дунджаар 2.88 өдөр хувийн машинтайгаа Их тойруугийн бүс рүү ордог бол хувиараа бизнес эрхлэгч нар 3.08 өдөр хөдөлгөөнд оролцож Их тойруугийн бүс рүү нэвтэрдэг байна.




# ЦЭЦЭРЛЭГ, БАГА СУРГУУЛИЙН ХҮҮХДИЙН ХАМРАН СУРАХ ТОЙРОГТОО СУРАЛЦАХ БАЙДАЛ


## УЛААНБААТАР ХОТЫН 10 ӨРХ ТУТМЫН 1 ӨРХИЙН ГИШҮҮН

### ХУВИАРАА ТАКСИНД ЯВДАГ

Танай өрхөд такси үйлчилгээнд явж орлого олдог хүн байдаг юу?



Такси үйлчилгээнд явахдаа бүтэн цагаар явдаг уу, эсвэл ажлын хажуугаар буюу хагас цагаар явдаг уу?




- Хувиараа таксинд явж орлого олдог иргэдийн 78% нь хагас цагаар буюу ажлын хажуугаар явдаг бол 22% нь бүтэн өдөр таксинд явж замын хөдөлгөөнд оролцдог байна.






# ОНОШИЛГОО, ДААТГАЛ, ТАТВАР, ТОРГУУЛЬ, ЗОГСООЛЫН ТӨЛБӨР, АЧИЛТЫН ТӨЛБӨР ЗЭРЭГТ УРСГАЛ ЗАРДАЛ ЖИЛИЙН ДҮН



## 409'148₮

1 ЖИЛД ДУНДЖААР АВТОМАШИНДАА ЗАРЦУУЛДАГ ЗАРДАЛ

Автомашинтай иргэд 1 жилд дунджаар 410 мянга орчим төгрөгийг урсгал зардалдаа зарцуулдаг байна. Иргэдийн 52% нь 100,000-500,000 төгрөгийг автомашиндаа зарцуулдаг байна.




## 59%

АВТО МАШИНДАА ЗАРЦУУЛЖ БУЙ ЗАРДАЛ НЬ БАГА БОЛОН БОЛОМЖИЙН ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА

Автомашинтай иргэдийн жилд зарцуулж буй мөнгөн дүн 30%-д нь их санагддаг бол 9% нь бага гэж боддог байна. Иргэдийн 50% нь автомашиндаа зарцуулж буй зардал нь боломжийн байдаг гэсэн байна.

**ИХ ЗАРДАЛ ГЭЖ БОДДОГ**



**БАГА ЗАРДАЛ ГЭЖ БОДДОГ**



**БОЛОМЖИЙН ГЭЖ САНАГДДАГ**

# УЛСЫН ДУГААРЫН ХЯЗГААРЛАЛТЫН ХЭРЭГЖИЖ БУЙ БАЙДАЛ

## ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ

“Жолооч нарын 60% нь дугаарын хязгаарлалтыг сайн мөрдөж байна гэж үзсэн бол 11% нь мөрдөгдөхгүй байна гэж үнэлжээ.”

“Жолооч нарын 82% нь дугаарын хязгаарлалттай өдөр замын хөдөлгөөнд оролцдоггүй бол 11% нь заримдаа, 7% нь байнга оролцдог байна.”



Асуулт: Та жолооч нарыг дугаарын хязгаарлалтыг хэр зэрэг мөрддөг гэж бодож байна вэ?

Асуулт: Та дугаарын хязгаарлалттай өдрийн, хязгаарласан цагт хязгаарласан цагаар автомашинаараа оролцдог уу?


# НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ



## АВТОБУСНЫ БУУДЛЫН ОЙР БАЙДАЛ

3.6


Иргэд автобус буудал хоорондын зайд дунджаар 3.6 оноо өгч байна.



## ХҮССЭН ЧИГЛЭЛ РҮҮ ЯВАХ МАРШРУТ БАЙГАА ЭСЭХ

3.07


Иргэд автобусны маршрутад дунджаар 3.07 оноо өгч байна.



## АВТОБУСНЫ ХҮРТЭЭМЖ, ХҮЛЭЭЛГИЙН ХУГАЦАА БАГА БАЙДАЛ

2.75


Иргэд автобусны буудлын хүртээмж, хүлээлгийн хугацаанд дунджаар 2.75 оноо өгч байна.



## АВТОБУСНЫ БУУДЛЫН ТОХИЖИЛТ


2.64

Иргэд автобусны буудлын тохижилтод дунджаар 2.64 оноо өгч байна.




- Нийтийн тээврээр үйлчлүүлэгчид нийтлэг байдлаар сэтгэл ханамж багатай ба автобусны буудал хоорондын зайн ойр байдалд бусад үзүүлэлттээс харьцангуй өндөр буюу дунджаар 3.6 оноо өгчээ.


# НИЙТИЙН ТЭЭВРЭЭР ЗОРЧИХОД ТУЛГАРДАГ БЭРХШЭЭЛҮҮД




Автобусаар хэт олон хүн зорчдог тул шахцалддаг, суудал олддоггүй




Автобусаар зорчиход тав тух муутай (муухай үнэртэй, өвөл хүйтэн, зун халуун, жолооч огцом тоормозлодог г.м)




Хүйтний улиралд автобус хүлээх хэцүү байдаг




Автобусны ирэх давтамж цөөн тул удаан хүлээдэг




Бага насны хүүхэдтэй хамт нийтийн тээврээр зорчиход хүндрэлтэй байдаг




Халаасны хулгайч ихтэй тул эд зүйлсээ алддаг




Согтуу хүмүүс, хоёрдогч түүхий эд түүдэг зорчигчид автобусанд суудаг




Автобусны буудал хол байдаг



Миний очих газарт автобусны буудал байдаггүй буюу чиглэл байхгүй



Чиглэлийн давхцал их




Бусад бэрхшээл


- Иргэдийн хувьд нийтийн тээврээр зорчиход автобусанд олон хүнтэй байдаг, шахцалддаг мөн тав тух муу байдаг нь хамгийн хүндрэлтэй байдаг ажээ.




# ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД АЛХАЖ ОРОЛЦОХОД ТУЛГАРДАГ БЭРХШЭЭЛҮҮД




Зуны улиралд явган хүний зам усанд автдаг тул харайх, усаар туулах шаардлагатай болдог




Явган хүний зам хангалттай биш, явган замын эвдрэл их




Өвлийн улиралд халтиргаа ихтэй, замын цасыг дутуу цэвэрлэдэг




Шороо, тоос ихтэй




Авто замын хажуугаар алхахад жолооч нар шавхайгаар цацдаг




Бага насны хүүхдээ дагуулан алхахад аюултай




Авто замын хажуугаар алхахад дуу чимээ их, мөргүүлэх эрсдэлтэй




Явган зам, дугуйн зам нь нэг дор байдаг тул дугуйтай хүмүүст мөргүүлэх гээд байдаг



Хашаа, хайс, шон, нүх их тааралддаг



Хүйтний улиралд алхахад хүйтэн байдаг




Бусад бэрхшээл


- УБ хотын иргэдийн хувьд зуны улиралд явган хүний зам усанд автдаг, мөн хүртээмжтэй биш, өвлийн улиралд халтиргаа ихтэй байдаг зэрэг нь хамгийн хүндрэлтэй байдаг байна.




# ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД УНАДАГ ДУГУЙ, СКУУТЕР УНАЖ ОРОЛЦОХОД ТУЛГАРДАГ БЭРХШЭЭЛҮҮД




Унадаг дугуйн зориулалтын зам байдаггүй




Унадаг дугуйн замууд энд, тэнд маш их тасарсан байдаг




Авто замаар дугуйгаар явахад жолооч нар сигналдаж, шахдаг тул осолд орох эрсдэлтэй байдаг




Дугуйн зогсоол ховор байдаг




Явган зорчигчийн зам нарийхан, боржур нь хэт өндөр байдаг тул дугуйгаар явахад хүндрэлтэй




Хашаа хайс их, шон, нүх ихтэй болохоор тойрч гарах нь хүндрэлтэй




Зуны улиралд авто зам, явган зам усанд автдаг тул дугуйгаар зорчиход хүндрэлтэй




Өвлийн улиралд халтиргаа ихтэй




Дугуйн эд зүйлсийг хулгайд алддаг



Авто замын хажуугаар дугуйтай явахад жолооч нар шавхай цацдаг



Дугуйн бүртгэл байдаггүй




Бусад бэрхшээл

- 2021 оны 1 сарын судалгаагаар түгжрэлийг бууруулахын тулд зоригтой арга хэмжээ авах цаг болсон гэдэгтэй 76% нь санал нийлж байжээ.
- 9 сарын хугацаанд уг дүн 15 пунктээр буюу 91% болж өссөн байна.

# ИРГЭДИЙН 91% НЬ ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХЫН ТУЛД ЗОРИГТОЙ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЦАГ БОЛСОН ГЭДЭГТЭЙ САНАЛ НИЙЛЖЭЭ.

- Иргэдийн 75% нь нийтийн тээврийн үйлчилгээ сайжирвал машины хэрэглээгээ бууруулна гэдэгтэй санал нийлж байгаа ба 69% нь явган алхах, дугуйгаар явах боломжийг нэмэгдүүлбэл машины хэрэглээгээ бууруулна гэж санал нийлсэн байна.
- Харин 66% нь автомашин зардалтай ч гэсэн хэрэглэсээр байх болно гэдэгтэй санал нийлж байна.
- Иргэдийн 50% нь жолоочийн хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд торгуулийг нэмэгдүүлэх ёстой гэж бодож байгаа бол 47% нь автомашины хэрэглээ нэмэгдэж байгаа тул хязгаарлах шаардлага үүссэн гэдэгтэй санал нийлж байна.



Түгжрэлийг бууруулахын тулд зоригтой арга хэмжээ авах цаг болсон

Хэрэв нийтийн тээврийн үйлчилгээ сайжирвал би машины хэрэглээгээ бууруулна

Явган алхах, дугуйгаар явах боломжийг нэмэгдүүлбэл би автомашины хэрэглээгээ бууруулна

Автомашин унах нь зардалтай ч гэсэн би хэрэглэсээр байх болно

Жолоочийн хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд торгуулийг нэмэгдүүлэх ёстой

Автомашины хэрэглээ нэмэгдэж байгаа тул хязгаарлах шаардлага үүсэж байна



Санал нийлж буй байдал

# ТОМООХОН, ЗАХ ХУДАЛДААНЫ ТӨВ, АВТО ВОКЗАЛААР ҮЙЛЧЛҮҮЛСЭН БАЙДАЛ, ДАВТАМЖ

- Сүүлийн нэг жилийн хугацаанд Нарантуул захаар иргэдийн 61% нь үйлчлүүлсэн бол 40% нь 100 айл, 38% нь Бөмбөгөр захаар тус тус үйлчлүүлсэн байна.
- Дүүргийн хувьд задлан харвал Баянзүрх дүүргийн иргэд Нарантуул зах, Дүнжингарав худалдааны төвөөр үйлчлүүлэх хандлага өндөр байна.
- Сонгинохайрхан дүүргийн иргэд Хархорин захаар гол төлөв үйлчлүүлдэг байна.

		Баянгол дүүрэг	Баянзүрх дүүрэг	Сонгино хайрхан дүүрэг	Сүхбаатар дүүрэг	Хан-Уул дүүрэг	Чингэлтэй дүүрэг	Өдөрт үйлчлүүлдэг хүний тоо дунджаар
Нарантуул зах	61%	50%	75%	52%	64%	59%	67%	42.8k
100 айл	40%	41%	46%	30%	48%	36%	46%	34.3k
Бөмбөгөр зах	38%	39%	33%	29%	44%	40%	58%	33.3k
Дэнжийн 1000 зах (Хүчит шонхор)	38%	37%	39%	27%	50%	30%	59%	29.0k
Хар хорин зах	36%	34%	22%	69%	17%	39%	20%	33.1k
Дүнжингарав зах	28%	25%	41%	16%	23%	35%	24%	15.9k
Драгон авто вокзал (баруун аймаг)	28%	27%	26%	37%	25%	24%	24%	20.3k
Барс зах	26%	35%	23%	27%	27%	24%	23%	23.6k
Да хүрээ зах (авто худалдаа)	21%	16%	34%	18%	15%	14%	23%	15.8k
Өгөөмөр зах (авто худалдаа)	21%	13%	31%	16%	20%	18%	20%	12.5k
Баянзүрх зах	18%	11%	36%	9%	16%	13%	15%	18.6k
Гурвалжин зах	17%	20%	14%	19%	12%	25%	14%	18.5k
Тэнгэр автовокзал (зүүн аймаг)	13%	7%	24%	8%	12%	10%	10%	7.6k
Лавай авто вокзал (говийн аймаг)	7%	7%	7%	4%	5%	15%	5%	4.6k

БҮЛЭГ 2.1

# ТҮГЖРЭЛИЙН ШИЙДЛИЙН ХУВИЛБАРУУД

Иргэдийн үнэлгээ



Mongolian Marketing  
Consulting Group


# ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХАД ЗАСГИЙН ГАЗРЫН ЗҮГЭЭС

## ХЭРЭГЖҮҮЛЭХ ГОЛ 5 АЖИЛ

### ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ

○ Засгийн газрын зүгээс ямар ажлыг хийвэл иргэд түгжрэлийг бууруулсан гэж үзэх, түгжрэл бууруулахад нөлөө үзүүлж чадахуйц хамгийн өндөр санал авсан 5 ажлыг доор харуулав.

Түгжрэлийг  
бууруулсан  
гэж үзэх  
байдал




Гэрийн ойролцоо цэцэрлэг сургуулийг шинээр барьж, хүрэлцээг нэмэгдүүлсэнээр иргэдийн 76% нь түгжрэл буурна гэж үзсэн байна.

Түгжрэлийг  
бууруулахын  
тулд хийх  
ажил



Нарантуул, Хүчит шонхор, Бөмбөгөр, 100 айл зэрэг томоохон зах, худалдааны төвүүдийг дэд төвүүдэд байгуулах, тархаан байршуулах ажлыг хийснээр түгжрэл буурна гэж 72% нь үзжээ.



Метро, их багтаамжит масс транзитыг барих, нэвтрүүлэх хэрэгтэй гэж иргэдийн 72% нь үзэж байгаа ба энэ ажлыг хийснээр түгжрэлийн бууруулна гэж иргэд дүгнэжээ.



Нийтийн тээврийн парк шинэчлэл хийж, тав тухтай, хурдан зорчдог болгох, автобусны буудлыг ойр болгох ажлыг хийснээр 61% нь түгжрэл буурна гэж үнэлсэн байна.




Ухаалаг гэрлэн дохионы системийг нэвтрүүлж оргил цаг болон ачаалалтай уулзваруудын хөдөлгөөний оновчтой зохицуулалтыг хийвэл иргэдийн 61% нь түгжрэл буурна гэсэн байна.



# ЗАСГИЙН ГАЗРЫН ЗҮГЭЭС ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ

## ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ

○ Засгийн газрыг гэрийн ойролцоо цэцэрлэг сургууль барьж, хүрэлцээг нэмэгдүүлэх, метро, их багтаамжит масс транзитыг барих, томоохон зах худалдааны төвүүдийг тархаан байршуулах ажлыг хийвэл түгжрэлийг бууруулахад хувь нэмэр оруулж түгжрэлийг бууруулна гэж иргэд үнэлсэн байна.




# ШИЙДЛИЙН ХУВИЛБАНУУД

## ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ – БҮЛЭГ БҮРИЙН ХАМГИЙН ИХ ДЭМЖЛЭГ АВСАН 5 ШИЙДЭЛ

<b>НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ, ШИНЭЧЛЭХ</b>	<b>ЗАХ ХУДАЛДААНЫ ТӨВ, АВТО ВОКЗАЛ ХҮН ТӨВЛӨРСӨН ГАЗРУУДЫГ ТАРХААХ</b>	<b>ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, АВТОЗАМЫН ОСЛЫГ БУУРУУЛАХ</b>	<b>АВТОМАШИНЫ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ</b>	<b>ТАТВАР ТӨЛБӨР ХУРААМЖ</b>
<p>Хүйтний улиралд тав тухтай байх автобусны буудлыг барих <b>74%</b></p>	<p>100 айл (барилгын материал) <b>82%</b></p>	<p>Замын хөдөлгөөний ноцтой зөрчлийн торгуулийг 3-5 дахин нэмэгдүүлэх <b>75%</b></p>	<p>Сургуулийн автобусыг нэмэх <b>86%</b></p>	<p>Агаарт ялгаруулах хорт хийн түвшингээр нь ялгаатай татвар оногдуулах <b>70%</b></p>
<p>Метро, хөнгөн төмөр замын тээвэр багтаамж ихтэй нийтийн тээврийн шинэ төрлийг нэвтрүүлэх <b>72%</b></p>	<p>Нарантуул захын өргөтгөл <b>75%</b></p>	<p>Жолооны курст суралцах хугацааг уртасгаж чанаржуулах, жолооны үнэмлэх олгох шалгуурыг чангаруулах <b>72%</b></p>	<p>Ажлын уян хатан цагийг нэвтрүүлэх <b>85%</b></p>	<p>Насжилт болон агаарын чанарын хорт хийн түвшин өндөр автомашины импортын татвар нэмэх, ялгаатай тогтоох <b>65%</b></p>
<p>Автобусны парк шинэчлэлт, <b>71%</b></p>	<p>Өгөөмөр зах (авто худалдаа) <b>75%</b></p>	<p>Осол гарсан тохиолдолд зааврын дагуу видео бичлэг хийж зам чөлөөлөх, чөлөөлөөгүй удсан тохиолдолд торгууль төлөх <b>69%</b></p>	<p>Эвдэрсэн, осолд орсон, их хэмжээний гэмтэлтэй, агаарын чанарын стандарт хангахгүй тээврийн хэрэгслийн импортыг хязгаарлах <b>80%</b></p>	<p>Нийслэлийн гол зам дагуу байрлах худалдаа, үйлчилгээний объектуудаас зурвас ашигласны татвар авах <b>56%</b></p>
<p>Автобусны буудлын орчныг сайжруулах, автобусны буудал хүртэл явах зам, гудамж орчныг тохижуулах <b>70%</b></p>	<p>Да хүрээ зах (авто худалдаа) <b>75%</b></p>	<p>Машин унаагүй хугацаанаас хамаарч торгуулиас хасдаг урамшууллын систем нэвтрүүлэх <b>70%</b></p>	<p>Харьяаллын дагуу хамран сургах тойрогтоо сургууль, цэцэрлэгт элсдэг болгох <b>72%</b></p>	<p>Авто зам ашигласны хураамжийг автомашины хэрэглээнд тулгуурлан авах <b>55%</b></p>
<p>Автобусны нэгдүгээр эгнээгээр зорчдог замыг уртасгаж, хүрээг нэмэгдүүлэх <b>69%</b></p>	<p>Нарантуул зах <b>73%</b></p>	<p>Жолоочийн хариуцлага, онооны системийг чангаруулах <b>68%</b></p>	<p>Долоогоос дээш жилийн насжилттай автомашины импортыг хязгаарлах <b>62%</b></p>	<p>Их тойруугийн бүсийн бүх зогсоолыг төлбөртэй болгох <b>36%</b></p>

# ЗАХ ХУДАЛДААНЫ ТӨВ, ТӨВЛӨРӨЛ ТАТДАГ ГАЗРУУДЫГ ТАРХААХТАЙ ХОЛБООТОЙ ШИЙДЛИЙН ХУВИЛБАНУУДЫГ ДЭМЖИЖ БУЙ БАЙДАЛ

- Хүний төвлөрөл ихээр татдаг зах худалдааны төв, авто вокзал, их дээд сургуулиудыг хотын төвөөс гаргах, тархаан байршуулахтай холбоотойгоор иргэдийн 82% нь 100 айлыг гаргах, задлах хэрэгтэй гэж хамгийн ихээр дэмжсэн байна.
- Нарантуул захын өргөтгөл 75%, Өгөөмөр зах 75%, Нарантуул зах 73% нь гаргах задлах хэрэгтэй гэж дэмжиж байгаа ба Нарантуул орчмын бүсийг хотоос гаргавал түгжрэлийг бууруулахад илүү нөлөөтэй гэж иргэд үнэлсэн байна.




# ЯВГАН ХҮНИЙ, УНАДАГ ДУГУЙН ЗАМЫГ САЙЖРУУЛАН, ШИНЭЭР ТОХИЖУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ШИЙДЭЛ

- Явган алхах таатай нөхцөлийг бүрдүүлвэл иргэдийн 62% нь явган алхах байдал нэлээд нэмэгдэнэ гэж хариулсан байна.
- 12% нь явган алхах байдал нэмэгдэхгүй гэсэн байна.

Хэрэв явган алхахад саад болж буй хайс, хашааг бүрэн чөлөөлж, явган замыг сайжруулан, аюулгүй зорчих боломжийг бий олговол таны явган алхаж ажилдаа явах, бусад ажлаа амжуулах байдал нэмэгдэх үү?

- Дугуйн замыг сайжруулан, аюулгүй зорчих боломжийг бүрдүүлбэл иргэдийн 66% нь 7 хоногт 1 болон түүнээс дээш удаа замын хөдөлгөөнд дугуйтай оролцоно гэжээ.

Хэрэв дугуйгаар зорчиход саад болдог хайс, хашааг бүрэн чөлөөлж, хотын төв рүү дугуйгаар зорчих зориулалтын замыг нэмэгдүүлж, аюулгүй зорчих боломжийг бүрдүүлбэл та ямар давтамжтай ажилдаа явах, бусад ажлаа амжуулах зорилгоор дугуйгаар хөдөлгөөнд орох вэ?





БҮЛЭГ 2.2

# НИЙТИЙН ТЭЭВРИЙГ САЙЖРУУЛАХ, LRT НЭВТРҮҮЛЭХ ШИЙДЭЛ

Иргэдийн үнэлгээ



Mongolian Marketing  
Consulting Group

# НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ, ШИНЭЧЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ШИЙДЛИЙН ХУВИЛБАРУУД


- Хүйтний улиралд тав тухтай байх автобусны буудлыг барьвал иргэдийн 74% нь нийтийн тээврээр зорчих байдал нь нэмэгдэнэ гэсэн бол 72% нь метро, хөнгөн төмөр замын тээвэр буюу их багтаамжит нийтийн тээврийн шинж төрлийг нэвтрүүлвэл нийтийн тээврээр хөдөлгөөнд оролцох байдал нь нэмэгдэнэ гэж үнэлсэн байна.
- Бусдаасаа бага үнэлгээ авсан шийдэл нь алслагдсан газруудад богино эргэлтийн жижиг оврын нийтийн тээврийг хөгжүүлэх болон албан ёсны такси үйлчилгээ байна.

Дэмжих буй байдал

■ + ■



# ИХ БАГТААМЖИТ НИЙТИЙН ТЭЭВЭР LRT НЭВТРҮҮЛЭХИЙГ ДЭМЖИЖ БУЙ БАЙДАЛ ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ



**90%** дэмжиж байна

Монорайл, LRT шинэ нийтийн тээврийн төрлийг нэвтрүүлэх, хөгжүүлэхийг иргэдийн 90% буюу 10 хүн тутмын 9 нь дэмжиж байна.



**65%** сөрөг нөлөөгүй

Монорайл, LRT шинэ нийтийн тээвэр нь Улаанбаатар хотын өнгө үзэмжид сөрөг нөлөөгүй гэж 65% нь үзсэн ба 88% нь хийх нь зөв гэж үнэлжээ.



**56%** 7 хоногт 4-өөс дээш удаа үйлчлүүлнэ


Уг нийтийн тээврийн төрлийг нэвтрүүлвэл иргэдийн 56% нь 7 хоногт 4-өөс дээш удаа үйлчлүүлэх бол 6% нь огт үйлчлүүлэхгүй гэж хариулсан байна.



# ИХ БАГТААМЖИТ НИЙТИЙН ТЭЭВРИЙН ТАСАЛБАРЫН ҮНЭ 1000₮ ДЭЭШ БАЙВАЛ ИРГЭДИЙН ҮЙЛЧЛҮҮЛЭХ БАЙДАЛ БУУРНА.




Уг LRT нийтийн тээврийн тасалбарын **ҮНЭ ХЭД БАЙВАЛ ҮЙЛЧЛҮҮЛЭХ** вэ?




- Шинэ төрлийн их багтаамжит нийтийн тээвэр LRT тасалбарын **үнэ 1000₮-с дээш байвал иргэдийн үйлчлүүлэх байдал 46%-с 11% болж багасч байна.**
- LRT нийтийн тээврийн тасалбарын **үнэ 1000₮-с байвал иргэдийн 37% нь буюу 318 мянга орчим иргэнд үнэтэй санагдаж эхлэх бөгөөд үйлчлүүлэхгүй байх хандлагатай** байна.
- Тасалбарын үнэ 1500₮-с дээш болвол иргэдэд үнэтэй санагдах байдал нь өсч байна.

LRT нийтийн тээврийн тасалбарын үнэ хэдэн ₮ болвол үнэтэй санагдаж **ҮЙЛЧЛҮҮЛЭХГҮЙ** болох вэ?






# ШИНЭ ТӨРЛИЙН НИЙТИЙН ТЭЭВЭР LRT-Г ЯАРМАГИЙН ЧИГЛЭЛД ЯВУУЛБАЛ ИРГЭДИЙН 56% НЬ ЯАРМАГТ АМЬДАРНА ГЭЖ ХАРИУЛЖЭЭ



- Их багтаамжит тусгай замын тээвэр LRT нь Яармагийн чиглэлд явдаг болбол иргэдийн 29% нь Яармагт амьдрахгүй гэсэн ба 15% нь хэлж мэдэхгүй гэж хариулсан байна.
- Сүхбаатар дүүргийн иргэд шинэ тээвэр явдаг болсон ч Яармагт амьдрахгүй гэж 36% нь үзэж байна.
- Төрийн байгууллагын иргэдийн 59% нь Яармагт амьдрах болно гэж хариулжээ.

■ Тийм ■ Үгүй ■ Хэлж мэдэхгүй



БҮЛЭГ 2.3

# АВТО ЗОГСООЛ, АЧИЛТЫН ТӨЛБӨР, ТАТВАР ХУРААМЖ НЭМЭГДҮҮЛЭХ ШИЙДЭЛ

Иргэдийн үнэлгээ



Mongolian Marketing  
Consulting Group

# ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, АВТОЗАМЫН ОСЛЫГ БУУРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ШИЙДЛИЙН ХУВИЛБАРУУД




- Иргэд ачилтын төлбөрийг нэмэхийг дэмжиж буй байдал хамгийн бага байна. Харин ноцтой торгуулийг 3-5 дахин нэмэгдүүлэхийг иргэдийн 88% нь дэмжиж байна.
- Жолооны курст суралцах хугацааг уртасгаж чанаржуулахыг 86% нь дэмжиж байна.

Дэмжиж буй байдал




- Огт дэмжихгүй байна
- Дэмжихгүй байна
- Бага зэрэг дэмжиж байна
- Ер нь дэмжиж байна
- Маш их дэмжиж байна

# АЧИЛТЫН ТӨЛБӨР 100 МЯНГАН ₮ БОЛОХОД ЖОЛООЧ НАРЫН 73% НЬ ДУРТАЙ ГАЗРАА АВТОМАШИНАА БАЙРЛУУЛАХГҮЙ БОЛНО ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА





# ХОТЫН ТӨВИЙН АВТО ЗОГСООЛЫН 1 ЦАГИЙН ТӨЛБӨР 1,500₮ БОЛОХОД ИРГЭДИЙН 40% НЬ ХОТЫН ТӨВ РҮҮ НИЙТИЙН ТЭЭВРЭЭР ЗОРЧИХЫГ ИЛҮҮД ҮЗЭХЭЭР БАЙНА




# ТАТВАР, ТӨЛБӨР ХУРААМЖТАЙ ХОЛБООТОЙ ШИЙДЛИЙН ХУВИЛБАРУУД

## ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ




- Иргэдийн 70% нь агаарт ялгаруулах хорт хийн түвшингээр нь ялгаатай татвар оногдуулахыг дэмжиж байна.
- Харин Их тойруугийн бүсийн бүх зогсоолыг төлбөртэй болгохыг 46% нь дэмжихгүй байна.

Дэмжиж буй байдал




# ИХ ТОЙРУУГИЙН БҮС РҮҮ НЭГ УДАА НЭВТРЭХ ТӨЛБӨРИЙГ 500₮ БОЛОХОД МАШИН УНАДАГ ИРГЭДИЙН 30% НЬ ХОТЫН ТӨВ РҮҮ ХУВИЙН МАШИНААРАА ЗОРЧИХГҮЙ ГЭЖ БАЙНА

Их тойруугийн бүс рүү хувийн авто машинтай нэвтрэхэд бүсчлэлийн хураамж авдаг болохыг та дэмжиж байна уу?



- Их тойруугийн бүс рүү нэвтрэхэд бүсчлэлийн хураамж авдаг болохыг иргэдийн 67% нь дэмжихгүй байгаа бол 29% нь дэмжиж байна.
- Хэрэв хотын төв буюу Их тойруугийн бүс рүү нэвтрэх төлбөр **500₮ болбол дэмжиж буй иргэдийн 30% буюу 57.5 мянган автомашинаар замын хөдөлгөөнд оролцдог иргэн** нийтийн тээврээр үйлчлүүлэхийг илүүд үзэхээр байна.
- Төлбөрийг нэмэх тусам хувийн машинаар Их тойруугийн бүс рүү зорчих байдал буурах хандлагатай байна.


Их тойруугийн бүс рүү нэг удаа нэвтрэхэд өгөх ХУРААМЖИЙГ ХЭДЭН ТӨГРӨГ БАЙХ НЬ ТОХИРОМЖТОЙ гэж үзэж байна вэ?



# АВТОМАШИНЫ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ШИЙДЛИЙН ХУВИЛБАРУУД - ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ


- Иргэдийн 86% нь сургуулийн автобусыг нэмэх, 85% нь ажлын уян хатан цагийг нэвтрүүлэх, 80% нь чанарын шаардлага хангахгүй тээврийн хэрэгслийн импортыг хязгаарлахыг дэмжсэн байна.
- Хамгийн бага дэмжлэг авсан шийдэл нь автомашины шинэ дугаар олголтод квот тогтоодог болохыг 46% нь дэмжиж, 34% нь дэмжихгүй байна.

Дэмжиж буй байдал  
+




# БУРУУ ХҮРДТЭЙ АВТОМАШИНЫГ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХЫГ ХОРИГЛОХ ЫГ ДЭМЖИЖ БУЙ БАЙДАЛ

## 2025 он




2025 оноос жолооны хүрд буруу талдаа автомашиныг замын хөдөлгөөнд оролцохыг хориглохыг иргэдийн 43% нь дэмжиж байна.

## 2028 он



2028 оноос буруу хүрдтэй автомашиныг Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцохыг хориглохыг иргэдийн 58% нь дэмжиж байна.

## 2030 он




2030 оноос буруу хүрдтэй автомашиныг Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцохыг хориглохыг иргэдийн 67% нь дэмжиж байна.




# Ирэх 10 жилийн хугацаанд бага хүүтэй зээлийн систем нэвтрүүлэх замаар Улаанбаатар хотын автомашины 50 хувийг агаарын бохирдолд сөрөг нөлөөгүй цахилгаан машин болгох бодлого явуулбал та дэмжих үү?

○ Иргэдийн 75% нь ирэх 10 жилийн хугацаанд Улаанбаатар хотын автомашины 50%-г агаарын бохирдолд сөрөг нөлөөгүй цахилгаан машин болгохыг дэмжиж байна.




- Хэлж мэдэхгүй байна
- Огт дэмжихгүй байна
- Дэмжихгүй байна
- Бага зэрэг дэмжиж байна
- Ер нь дэмжиж байна
- Маш их дэмжиж байна

Дэмжиж буй байдал



# АВТОМАШИНЫ БҮРТГЭЛИЙН ХУРААМЖ, ОНОШИЛГООНЫ ТӨЛБӨРТЭЙ ХОЛБООТОЙ ШИЙДЭЛ ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ


“Иргэдийн 75% нь автомашины тогтмол бүртгүүлж бүртгэлийн хураамж төлдөг болохыг дэмжиж байна.”



- Огт дэмжихгүй байна      ■ Дэмжихгүй байна
- Бага зэрэг дэмжиж байна   ■ Ер нь дэмжиж байна
- Маш их дэмжиж байна      ■ Хэлж мэдэхгүй байна

**Асуулт:** Жил бүр өөрийн автомашинаа бүртгүүлж, хураамж төлдөг болохыг та дэмжиж байна уу?

“Нийт иргэдийн 74% нь автомашины оношилгооны төлбөрийг нэмэгдүүлэхийг дэмжихгүй байна.”




- Огт дэмжихгүй байна      ■ Дэмжихгүй байна
- Бага зэрэг дэмжиж байна   ■ Ер нь дэмжиж байна
- Маш их дэмжиж байна      ■ Хэлж мэдэхгүй байна

**Асуулт:** Суудлын автомашины оношилгооны төлбөр 22,000 ₮ байгаа. Үүнийг нэмэхийг та дэмжиж байна уу?

# АГААРЫН БОХИРДОЛЫН ХУРААМЖИЙГ 68% НЬ БОЛОМЖИЙН ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА

- Агаарын бохирдлын хураамжийг иргэдийн 68% нь боломжийн байна гэж бодож байгаа бол 14% нь их гэж, 18% нь бага байна гэсэн хариулт өгчээ.
- Хураамжийг 9500 төгрөгөөс дээш байлгах нь тохиромжтой гэж 34% нь үзэж байгаа бол 66% нь одоогийн байгаа түвшинд болон түүнээс бага байх нь тохиромжтой гэж хариулжээ.

Агаар бохирдуулсны хураамж ямар түвшинд байна гэж бодож байна вэ?



Агаарын бохирдолын хураамжийг хэдэн төгрөг болгох нь тохиромжтой вэ?




Агаарын бохирдолын хураамж	Хөдөлгүүрийн багтаамж			
	1500-2500 см3	2501-3500 см3	3501-4500 см3	4501 см3-с дээш
Бага байна	16%	24%	20%	36%
Боломжийн байна	69%	65%	67%	52%
Их байна	15%	11%	14%	12%

Агаарын бохирдолын хураамж	Хөдөлгүүрийн багтаамж			
	1500-2500 см3	2501-3500 см3	3501-4500 см3	4501 см3-с дээш
2100₮ хүртэл	29%	21%	28%	14%
2100₮-9500₮	34%	33%	31%	18%
9500₮ дээш	37%	46%	41%	68%

# АВТОЗАМ АШИГЛАСАН ТАТВАРЫГ 62% НЬ 20'000 ₮ ХҮРТЭЛ БАЙХАД ТОХИРОМЖТОЙ ГЭЖ ҮНЭЛСЭН БАЙНА

- Автозам ашигласан татварын одоогийн түвшин нь их байна гэж иргэдийн 27% нь үзэж байгаа бол 8% нь бага байна гэсэн хариулт өгчээ.
- Татварыг хэд болговол тохиромжтой байх талаар тодруулахад 62% нь 20мянган төгрөг хүртэл байх нь тохиромжтой гэсэн бол 28% нь 20мянгаас 40 мянга байх нь тохиромжтой гэсэн байна.


Автозам ашигласны татвар ямар түвшинд байна гэж бодож байна вэ?



**БОЛОМЖИЙН САНАГДДАГ**

Автозам ашигласны татвар	Хөдөлгүүрийн багтаамж			
	1500-2500 см3	2501-3500 см3	3501-4500 см3	4501 см3-с дээш
Бага байна	8%	10%	14%	26%
Боломжийн байна	63%	65%	56%	59%
Их байна	29%	24%	30%	15%

Автозам ашигласны татварыг хэдэн төгрөг болгох нь тохиромжтой вэ?



Автозам ашигласны татвар	Хөдөлгүүрийн багтаамж			
	1500-2500 см3	2501-3500 см3	3501-4500 см3	4501 см3-с дээш
20000₮ хүртэл	67%	55%	66%	35%
20000₮-40000₮	23%	32%	21%	26%
40000₮ дээш	10%	13%	14%	39%

# ТАНАЙ ӨРХИЙН АМЬДАРЧ БУЙ БАЙРШИЛД ЯМАР, ЯМАР ҮЙЛЧИЛГЭЭ ОЙРХОН БАЙВАЛ ТАНЫ ХОТЫН ТӨВ РҮҮ ЯВАХ ХӨДӨЛГӨӨН БУУРАХ ВЭ?

- Амьдарч буй байршилд нь сургууль, цэцэрлэг, эмнэлэг ойрхон байвал хотын төв рүү явах хөдөлгөөн буурах хандлагатай байгаа байна.
- Дүүрэг тус бүрээр харвал СХД-т эдгээр газрууд бусад дүүрэгтэй харьцуулахад хомс байна.




Баянгол дүүрэг	Баянзүрх дүүрэг	Сонгино хайрхан дүүрэг	Сүхбаатар дүүрэг	Хан-Уул дүүрэг	Чингэлтэй дүүрэг
44%	40%	49%	40%	40%	47%
40%	37%	47%	40%	37%	44%
37%	35%	47%	35%	34%	43%
30%	31%	43%	30%	37%	38%
26%	29%	44%	33%	39%	39%
36%	31%	39%	30%	28%	36%
27%	23%	32%	26%	24%	34%
23%	25%	32%	21%	24%	29%
23%	21%	28%	22%	23%	26%
9%	9%	7%	15%	8%	14%



# ИРГЭДИЙГ ЯАРМАГИЙН БҮСЭД АМЬДРУУЛАХЫН ТУЛД ШИЙДСЭН БАЙХ ЁСТОЙ АСУУДАЛ

- Яармагийн бүсэд ажлын байр, сургууль цэцэрлэг, авто замыг шийдсэн байх шаардлагатай гэж иргэдийн хамгийн их дүгнэсэн байна.
- Төрийн байгууллагынхан хамгийн эхлээд сургууль цэцэрлэгийг шийдсэн байх ёстой гэж үзэж байгаа бол хувийн байгууллагынхан ажлын байрыг шийдсэн байх ёстой гэжээ.



Баянгол дүүрэг	Баянзүрх дүүрэг	Сонгино хайрхан дүүрэг	Сүхбаатар дүүрэг	Хан-Уул дүүрэг	Чингэлтэй дүүрэг
71%	77%	75%	74%	68%	77%
75%	75%	74%	65%	70%	76%
64%	66%	65%	65%	64%	65%
62%	63%	64%	55%	56%	67%
62%	60%	64%	57%	56%	64%
58%	60%	63%	54%	60%	65%
48%	52%	55%	49%	48%	59%
9%	7%	9%	14%	15%	14%

Төрийн байгууллага	Хувийн байгууллага	Хувиараа бизнес эрхлэгч
72%	76%	71%
76%	72%	71%
66%	64%	64%
65%	60%	60%
60%	61%	58%
62%	60%	58%
56%	52%	50%
11%	10%	13%

# ХУРААНГУЙ ҮР ДҮН



Mongolian Marketing  
Consulting Group

# ИРГЭДИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХ БАЙДАЛ



**55%** Хувийн автомашинтай

**80%** Суудлын автомашин

**2008** дунджаар онд үйлдвэрлэгдсэн

**51%** 7 хоногт 3+ өдөр замын хөдөлгөөнд ордог



**59%** Машинд гаргаж буй зардлаа боломжийн гэж боддог

**410 мянга** Жилд дунджаар зарцуулж буй мөнгөн дүн

**40%** Дугаарын хязгаарлалт төдийлөн мөрдөгдөхгүй байна



**3 хүүхэд тутмын 1** харьяа сургуульдаа явдаггүй



Хагас цаг **78%**  
Бүтэн цаг **22%**  
**10 өрх тутмын 1** өрх нь таксинд явдаг

**41%** 7 хоногт 3+ өдөр автобус, нийтийн тээвэр ашигладаг

Сэтгэл ханамжгүй %      Хүндрэл бэрхшээл




Буудал ойр байдал




Маршрут хүрэлцээ



Хүртээмж, хүлээлгийн хугацаа




Буудлын тохижилт



Хэт олон хүнтэй



Тав тух муутай



Хүйтэнд хүлээх



Удаан хүлээх



Хүүхэдтэй зорчих хэцүү

## Автозамын түгжрэлийн шалтгаан



## Иргэдийн бодол



## Их тойруугийн бүс рүү ордог зорилго



**3 хүн тутмын 2** нь Төрийн үйлчилгээ авдаг



**49%** нь ажилдаа явдаг



**46%** хувийн машинаар 7 хоногт 3+ өдөр ордог


# ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ҮР ДҮН



Хүний төвлөрөл  
ихээр татдаг  
зах,  
худалдааны  
төвүүдийг  
тархаан  
байршуулах

Зах, худалдааны төв	Өдөрт дунджаар үйлчлүүлж буй хүн	Үйлчлүүлсэн байдал, жилд
Нарантуул зах	<b>42.8 мянга</b>	61%
100 айл	<b>34.3 мянга</b>	40%
Бөмбөгөр зах	<b>33.3 мянга</b>	38%
Хархорин зах	<b>33.1 мянга</b>	38%
Дэнжийн 1000 зах	<b>29.0 мянга</b>	36%

Тархаан байршуулахыг дэмжих байдал



Дэд төвүүдийг хөгжүүлэх, LRT нэвтрүүлэх, Яармагийн бүсэд суурьшихтай холбоотой шийдлийн үнэлгээ



Тасалбарын үнэ: <1000₮

**90%** LRT-г дэмжиж байна

**65%** өнгө үзэмжид сөрөг нөлөөгүй

**56%** Яармагт амьдарна 7 хоногт 4+ удаа үйлчлүүлнэ

Дэд төвүүдэд байх шаардлагатай үйлчилгээ




Яармагт шийдсэн байх асуудал



## Засгийн газраас хэрэгжүүлэх иргэдийн дэмжсэн ТОП-5 ажил



### Иргэдийн дэмжих байдал




Гэрийн ойролцоо цэцэрлэг сургуулийг шинээр барьж, хүрэлцээг нэмэгдүүлэх




Томоохон зах, худалдааны төвүүдийг дэд төвүүдэд байгуулах, тархаан байршуулах ажил



Метро, их багтаамжит масс транзитыг барих, нэвтрүүлэх



Нийтийн тээврийн парк шинэчлэл хийж, тав тухтай, хурдан зорчдог болгох, автобусны буудлыг ойр болгох



Ухаалаг гэрлэн дохионы системийг нэвтрүүлж оргил цаг болон ачаалалтай уулзваруудын хөдөлгөөний оновчтой зохицуулалтыг хийх



### НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ, ШИНЭЧЛЭХ

Хүйтний улиралд тав тухтай байх автобусны буудлыг барих



Метро, хөнгөн төмөр замын тээвэр багтаамж ихтэй нийтийн тээврийн шинэ төрлийг нэвтрүүлэх



Автобусны парк шинэчлэлт



Автобусны буудлын орчныг сайжруулах, автобусны буудал хүртэл явах зам, гудамж орчныг тохижуулах



Автобусны нэгдүгээр эгнээгээр зорчдог замыг уртасгаж, хүрээг нэмэгдүүлэх



### ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, АВТОЗАМЫН ОСЛЫГ БУУРУУЛАХ

Замын хөдөлгөөний ноцтой зөрчлийн торгуулийг 3-5 дахин нэмэгдүүлэх



Жолооны курст суралцах хугацааг уртасгаж чанаржуулах, жолооны үнэмлэх олгох шалгуурыг чангаруулах



Машин унаагүй хугацаанаас хамаарч торгуулиас хасдаг урамшууллын систем нэвтрүүлэх



Осол гарсан тохиолдолд зааврын дагуу видео бичлэг хийж зам чөлөөлөх, чөлөөлөөгүй удсан тохиолдолд торгууль төлөх



Жолоочийн хариуцлага, онооны системийг чангаруулах



### АВТОМАШИНЫ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ

Сургуулийн автобусыг нэмэх



Ажлын уян хатан цагийг нэвтрүүлэх



Эвдэрсэн, осолд орсон, их хэмжээний гэмтэлтэй, агаарын чанарын стандарт хангахгүй тээврийн хэрэгслийн импортыг хязгаарлах



Харьяаллын дагуу хамран сургах тойрогтоо сургууль, цэцэрлэгт элсдэг болгох



Долоогоос дээш жилийн насжилттай автомашины импортыг хязгаарлах



### ТАТВАР ТӨЛБӨР ХУРААМЖ

Агаарт ялгаруулах хорт хийн түвшингээр нь ялгаатай татвар оногдуулах



Насжилт болон агаарын чанарын хорт хийн түвшин өндөр автомашины импортын татвар нэмэх, ялгаатай тогтоох



Нийслэлийн гол зам дагуу байрлах худалдаа, үйлчилгээний объектуудаас зурвас ашигласны татвар авах



Авто зам ашигласны хураамжийг автомашины хэрэглээнд тулгуурлан авах



Их тойруугийн бүсийн бүх зогсоолыг төлбөртэй болгох





# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА



Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо,  
Зүүн хүрээ хотхон, 203-р барилга, 4 давхарт



976 77000188



info@mmcg.mn



www.mmcg.mn



mmcgllc